



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2026 VI

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 6 дугаар сар

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2022-2026 он	7
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	7
I.	Нийгмийн даатгал, халамж	8
II.	Эрүүл мэнд	14
III.	Гэмт хэрэг	17
IV.	Төсөв	25
V.	Хэрэглээний үнэ	28
VI.	Аж үйлдвэр	33
VII.	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	38

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин их
- 1/X** дахин бага
- 0.0 маш бага тоо
- | харьцуулагдахгүй
- 0.0⁺ тэнцүү/ өөрчлөлтгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.


IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



МЭДЭЭЛЭЛ

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI
Шинээр төрсөн хүүхэд		Хүн	1 890 ^{↓21.8}	1 991 ^{↑5.3}	1 594 ^{↓20.0}	1 575 ^{↓1.2}	1 529 ^{↓2.9}
Халдварт өвчнөөр өвчлөгчсөд		Хүн	23 527 ^{↑70.2}	1 199 ^{↓94.9}	1 173 ^{↓2.2}	2 732 ^{↑132.9}	1 484 ^{↓45.7}
Бүртгэгдсэн гэмт хэрэг		Тоо	2 938 ^{↑2.61}	2 238 ^{↓23.8}	2 407 ^{↑7.6}	3 516 ^{↑46.1}	3 675 ^{↑4.5}
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		Хувь	1.5 ^{↓0.5}	1.1 ^{↓26.7}	0.4 ^{↓63.6}	0.3 ^{↓25.0}	1.5 ^{↑5.0**}
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	3 124 ^{↑9.7}	3 438 ^{↑10.1}	3 381 ^{↓1.7}	3 578 ^{↑5.8}	3 577 ^{↓0.1}
	Юань (БНХАУ)	Төгрөг	467 ^{↑5.4}	479 ^{↑2.6}	466 ^{↓2.7}	498 ^{↑6.9}	528 ^{↑6.0}
	Рубль (ОХУ)	Төгрөг	55 ^{↓4.9}	41 ^{↑25.5}	39 ^{↓4.9}	45 ^{↑15.4}	48 ^{↑6.7}
Дүүргийн төсвийн орлого		Тэрбум төгрөг	51.9 ^{↓11.6}	86.7 ^{↑67.1}	123.7 ^{↑42.7}	139.2 ^{↑12.5}	167.5 ^{↑20.3}
Дүүргийн төсвийн зарлага		Тэрбум төгрөг	34.7 ^{↓4.1}	62.6 ^{↑80.4}	94.4 ^{↑50.8}	153.0 ^{↑62.1}	155.4 ^{↑1.6}
Агаарын дундаж температур		°C	17.1	17.3	16.1	10.9	13.0

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-VI						2026 I-VI					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага			Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59	357	
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1490	Багануур	47		
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	Багануур	22	Хан-Уул	9	14	Налайх	20	Хан-Уул	9	14	
			Сүхбаатар	16	Баянгол	10		Багануур	25	Баянгол	6		
			Налайх	15	Багахангай	-		Баянзүрх	14	Багануур	-		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	131	Баянзүрх	144	Сонгинохайрхан	89	87	Багануур	115	Хан-Уул	56	87	
			Хан-Уул	115	Налайх	39		Баянзүрх	87	налайх	44		
			Баянгол	107	Багахангай	36		Чингэлтэй	733	Багахангай	9		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	83	Сүхбаатар	110	Баганхангай	77	100	Сүхбаатар	394	Багахангай	68	100	
			Хан-Уул	112	Багануур	24		Хан-Уул	453	Багануур	24		
			Баянзүрх	111	Налайх	86		Баянгол	330	Налайх	77		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	88	Сүхбаатар	235	Баганхангай	44	166	Сүхбаатар	256	Налайх	56	166	
			Чингэлтэй	145	Налайх	75		Чингэлтэй	206	Багахангай	45		
			Баянгол	145	Багахангай	44		Баянгол	179	Багануур	102		



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар, нийгмийн даатгалын зарлага 14.7 хувиар тус тус өссөн байна.


2026 оны 6 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 302.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.2 (15.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2025 VI	2026 VI	<u>2026 VI</u> <u>2025 VI</u>
	сая төгрөг		хувь
Нийт орлого	261 634.5	302 806.4	15.7
Тэтгэврийн даатгалын сангийн	217 108.5	251 077.1	15.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	23 143.6	26 905.5	16.3
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	13 243.8	15 404.3	16.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	8 138.6	9 419.5	15.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн	-	-	-
Нийт зарлага	233 059.7	267 292.5	14.7
Тэтгэврийн даатгалын сангийн	208 222.6	236 891.2	13.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	12 796.4	15 199.6	18.8
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	1 341.8	1 439.7	7.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	10 698.9	13 762.0	28.6


¹ -Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2026 оны 6 дугаар сард



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.9 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 8.9 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 3.1 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 2.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2026 оны 6 дугаар сард

Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 6 дугаар сарын байдлаар даатгуулагч иргэдэд 267.3 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.2 (14.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 88.6 хувийг тэтгэврийн, 0.5 хувийг ҮОМШӨ-ний, 5.7 хувийг тэтгэмжийн, 5.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2025 VI	2026 VI	2026 VI 2025 VI	2025 VI	2026 VI	2026 VI 2025 VI
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Сангийн нийт зарлага	46 683	46 579	-0.2	232 906.3	267 292.5	14.8
Тэтгэврийн даатгалын сан	35 105	36 339	3.5	208 210.2	236 891.2	13.8
Өндөр насны	28 175	29 332	4.1	170 132.5	193 912.1	14.0
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр	3 856	3 788	-1.8	15 290.3	16 942.1	10.8
Тэжээгчээ алдсаны	1 169	1 248	6.8	4 758.7	5 696.2	19.7
Цэргийн тэтгэвэр	1 905	1 971	3.5	18 028.7	20 328.5	12.8
Бусад зардал	-	-	-	-	12.4	-
Тэтгэмжийн даатгалын сан	8 941	7 405	-17.2	12 701.1	15 199.6	19.7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	6 595	5 119	-22.4	3 104.4	2 751.9	-11.4
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	1 959	1 829	-6.6	8 802.7	10 949.8	24.4
Оршуулгын тэтгэмж	387	457	18.1	794.0	1 372.5	72.9
Бусад зардал	-	-	-	-	125.4	-
ҮОМШӨ¹-ний даатгалын сан	261	280	7.3	1 296.2	1 439.7	11.1
Тахир дутуугийн тэтгэмж	148	141	-4.7	951.9	970.3	1.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	25	25	-	175.9	188.9	7.4
Тэтгэмж, төлбөр	88	103	17.0	167.7	226.0	34.8
ҮОМШӨ ¹ -ний сувилал	-	8	-	0.7	9.4	1.2**
Бусад зардал	-	3	-	-	45.1	-
Ажилгүйдлийн даатгалын сан	2 376	2 555	7.5	10 698.8	13 762.0	28.6
Ажилгүйдлийн тэтгэмж	2 376	2 555	7.5	10 698.8	13 762.0	28.6


Нийгмийн даатгал

2026 оны 6 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 46579 иргэнд 267292.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 36339 иргэнд 236891.2 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 7405 иргэнд 15199.6 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын

сангаас, 2555 иргэнд 13762.0 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 280 иргэнд 1439.7 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо, жил бүрийн 6 дугаар сард



2026 оны 6 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 46579 иргэнд 267.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 80.7 хувийг өндөр настны, 10.4 хувийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4

хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчдийн 80.7 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1157 (4.1%) иргэнээр, 23.8 (14.0%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн зарлага өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буурсан байна.

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжийн сангаас 2026 оны 6 дугаар сарын байдлаар нийт 758.7 мянган иргэнд 89060.6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдож, өнгөрсөн оны мөн үеэс 13552 (1.8%) иргэнээр өссөн бол 5192.9 (5.5%) сая төгрөгөөр буурсан байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 57622.2 (64.7%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 7898.8 (8.9%) сая төгрөгийг нийгмийн

халамжийн тэтгэвэрт, 9174.7 (10.3%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 2840.4 (3.2%) сая төгрөгийг эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, үлдсэн 11524.6 (12.9%) сая төгрөгийг онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, ахмад настны тэтгэмж хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж болон бусад тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2025 VI		2026 VI		2026 VI 2025 VI
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	хувь
Нийт олгогдсон тэтгэвэр, тэтгэмж	745 109	94 253.5	758 661	89 060.6	-5.5
Тэтгэвэр	16 550	6 482.5	17 546	7 898.8	21.8
Асаргааны тэтгэмж	26 292	7 598.9	27 986	9 174.7	20.7
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	53 345	2 986.6	48 700	2 840.4	-4.9
Алдарт эхийн одонгийн тусламж	12 694	2 965.9	13 407	3 110.3	4.9
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	51	18.6	60	26.8	44.1
Хүүхдийн мөнгө	576 933	57 693.3	576 222	57 622.2	-0.1
Насны хишиг	29 741	2 397.5	32 139	2 578.8	7.6
Онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	10	12.0	15 888	4.3	-64.2
Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	4 608	895.1	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	2 353	147.3	-	-	-
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	13 378	2 839.2	15 871	4 252.1	49.8
Бусад	9 154	1 067.8	10 842	1 552.3	45.4

Энэ оны 6 дугаар сарын байдлаар 5328 ахмадад 1265.1 сая төгрөгийн ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт зарцуулагдсан нь өмнөх оны мөн

үетэй харьцуулбал 720 (15.6%) хүн, 370.0 (41.3%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2025 VI		2026 VI		2026 VI 2025 VI
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	4 608	895 105.3	5 328	1 265 127.6	41.3
Оршуулгын тэтгэмж	19	38 000.0	7	20 000.0	-47.4
Амралт, сувилал	982	255 940.0	1 256	323 670.0	26.5
Рашаан, сувилал	2 056	364 156.3	2 335	621 655.0	70.7
Протез	1 273	162 577.0	1 273	165 060.0	1.5
Ортопед, тусгай хэрэгсэл	276	74 152.0	445	132 882.6	79.2
Ахмадын хүндэтгэл	-	-	-	-	-
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	2	280.0	12	1 860.0	5.6**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал хүний тоо 295 (12.5%), олгосон тэтгэмж 96.6 (65.6%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, төрлөөр, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2025 VI		2026 VI		2026 VI 2025 VI
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	2 353	147 306.4	2 648	243 873.1	65.6
Харилцаа, холбооны зардлын хөнгөлөлт	2 015	39 747.8	1 993	39 779.8	0.1
Оршуулгын тэтгэмж	20	40 000.0	11	33 000.0	-17.5
Цэцэрлэг сургуулийн унааны зардал	24	4 800.0	20	4 000.0	-16.7
Рашаан сувилал	68	16 493.6	68	26 630.7	61.5
Протез	62	10 735.0	102	21 820.0	1.0**
Ортопед тусгай хэрэгсэл	104	27 130.0	413	112 902.6	3.2**
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	60	8 400.0	41	5 740.0	-31.7
Бусад	-	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламж авсан нийт хүний дийлэнх буюу 75.3 хувийг харилцааны холбооны зардлын хөнгөлөлт авсан иргэд эзэлж байгаа боловч

олгосон тэтгэмж нь 16.3 хувь байна. Харин ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж авсан иргэдийн мөнгөн дүн 46.3 буюу хамгийн их хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны 6 сард 1 507 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 59 (3.8%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 6 сард 1507 эх амаржиж, 1529 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 56 (3.8%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 46 (2.9%)

хүүхдээр тус тус буурсан байна. Амьгүй төрөлтийн 6 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн дунд гэртээ төрсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ХҮСНЭГТ 8.

ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 6 сард


Үзүүлэлт	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	1 582	1 566	1 507	-3.8
Гэрийн төрөлт	1	2	-	-
Хяналтгүй төрөлт	3	5	6	20
Амьгүй төрөлт	4	4	6	50
Амьд төрсөн хүүхэд	1 594	1 575	1 529	-2.9
Эхийн эндэгдэл	-	1	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	20	16	9	-43.8
1-5 настай хүүхдийн эндэгдэл	3	1	2	100.0
Нас барсан хүн	480	450	463	2.9

2026 оны эхний 6 сард 0-1 хүртэл насандаа эндсэн 9 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 7 (43.8%)-аар буурсан байгаа бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл 2 бүртгэгдсэн байна.

Дүүргийн хэмжээнд нас баралт 463 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 13 (2.9%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 4.

ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Дүүрэгт 2026 оны эхний 6 сарын байдлаар 1484 халдварт өвчин бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1248 (45.7%) тохиолдлоор буурсан байна. Цочмог халдварт өвчний 27.7 хувийг салхин

цэцэг, 3.5 хувийг улаан эсэргэнэ, 35.8 хувийг энтеровируст цэврүүт фарингит, 9.6 хувийг улаан бурхан, 23.4 хувийг цусан суулга, ёлом, гепатит, сальмонеллёз зэрэг өвчин тус тус эзлээд байна.

ХҮСНЭГТ 9. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 6 сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	1 161	2 732	1 484	-1 248	-45.7
	10000 хүнд	-	69.6	57.5	-12.1	
Вируст гепатит	тоо	14	11	5	-6	-54.5
	10000 хүнд	-	0.2	0.2	-	
Цусан суулга	тоо	62	49	24	-25	-51.0
	10000 хүнд	-	1.9	0.9	-1.0	
Салмонеллт	тоо	12	20	17	-3	15.0
	10000 хүнд	-	0.8	0.7	-0.1	
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	тоо	-	7	2	-5	-71.4
	10000 хүнд	-	0.3	0.1	-0.2	
Хоолны хордлого	тоо	3	44	10	-34	-77.3
	10000 хүнд	0.1	1.7	0.4	-1.3	
Энтервируст халдвар тодорхойгүй/B34.1/	тоо	-	96	52	-44	-45.8
	10000 хүнд	-	3.7	2.0	-1.7	
Салхинцэцэг	тоо	432	423	328	-95	-22.5
	10000 хүнд	13.8	16.5	12.8	-3.7	
Гахай хавдар	тоо	25	5	7	2	40.0
	10000 хүнд	0.9	0.2	0.3	0.1	
Улаан эсэргэнэ	тоо	53	43	42	-1	-2.3
	10000 хүнд	2.04	1.7	1.6	-0.1	
Ёлом	тоо	5	11	6	-5	-45.5
	10000 хүнд	0.2	0.4	0.2	-0.2	
Бруцеллөз	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Менингококкт халдвар	тоо	-	1	2	1	100.0
	10000 хүнд	-	-	0.1	0.1	
Энтервируст тууралттай цэврүүт фарингит	тоо	136	77	425	348	5.5**
	10000 хүнд	4.4	3.0	16.5	13.5	
Эритема	тоо	1	96	32	-64	-66.7
	10000 хүнд	-	3.7	1.2	-2.5	
Улаан бурхан	тоо	-	1 399	114	-1 285	-91.9
	10000 хүнд	-	54.6	4.4	-50.2	
Спирохетээр сэдээгдсэн бусад өвчин	тоо	-	-	1	1	-
	1000 хүнд	-	-	-	-	
Хачгаар дамжих вируст энцефалит, тодорхойгүй A84.9	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	
Хачигт рикеттсиоз	тоо	1	1	8	7	8.0**
	10000 хүнд	-	0.0	0.3	0.3	-
Бусад халдварт өвчин	тоо	-	83	110	27	32.5
	10000 хүнд	-	3.2	4.3	1.1	
Тэмбүү	тоо	208	154	140	-14	9.1
	10000 хүнд	7.1	6.0	5.4	-0.6	
Гонококкт халдвар	тоо	53	70	33	-37	-52.9
	10000 хүнд	2.1	2.7	1.1	-1.6	

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Трихомониаз	тоо	68	42	44	2	4.8
	10000 хүнд	1.6	1.6	1.7	0.2	
Сүрьеэ	тоо	88	100	80	-20	-20.0
	10000 хүнд	3.5	3.9	3.1	-0.8	
ДОХ	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Мөөгөнцөр	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	

Өнгөрсөн оны мөн үеэс гоногкоккт халдвар 37 (52.9%) тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 5.4 нь тэмбүү өвчнөөр өвчилж байна.

Баянгол дүүрэгт 2026 оны эхний 6 сард 1186 хүн цочмог халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1180 (49.9%) хүнээр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр:

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн сарын мэдээ



ГЭМТ ХЭРЭГ

Баянгол дүүрэгт 3675 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 159 (4.5%) хэргээр өссөн байна.

2026 оны 6 сард 3675 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 159 (4.5%) хэргээр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 47.9 хувьтай байгаа нь 15.5 нэгж хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 3343 иргэн хохирч, 31.2 сая төгрөгийн хохирол учруулснаас 10.0 сая (51.6%) төгрөгийг нөхөн төлүүлжээ. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 49.9 хувийг залилан, 11.9 хувийг хүний

эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 14.2 хувийг хулгайн, 2.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 0.6 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг, 2.0 хувийг дээрмийн, 0.8 хувийг хүчин, 0.3 хувийг хүнийг санаатай алах, 17.7 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 10.


БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 6 дугаар сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 VI	2025 VI	2026 VI	Тоо	Хувь
Нийт гэмт хэрэг	2 407	3 516	3 675	159	4.5
Хүнийг санаатай алах	13	8	10	2	25.0
Хүний амьд явах эрхийн эсрэг	21	33	23	-10	-30.3
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	450	524	439	-85	-16.2
Хүчиндэх	22	40	31	-9	-22.5
Хулгайлах	476	620	522	-98	-15.8
Дээрэмдэх	59	101	72	-29	-28.7
Залилан	892	1 624	1 835	211	13.0
Танхайрах	0	2	2	-	-
ХАБТХАЖЭ	82	89	96	7	7.9
Бусад гэмт хэрэг	392	475	645	170	35.8

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг өссөн сөрөг үзүүлэлтэд хүнийг санаатай алах 2 (25.0%), залилан 211 (13.0%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 7 (7.9%), бусад гэмт хэрэг 170 (35.8%) нэгжээр тус тус

өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хүний амьд явах эрхийн эсрэг 10 (30.3%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 85 (16.2%), хүчин 9 (22.5%), хулгайлах 98 (15.8%), дээрэмдэх 29 (28.7%) нэгж хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 5.

БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 6 дугаар сард

Бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 400 (76.6%) нь иргэдийн өмчийн, 59 (16.7%) нь халаасны, 8 (2.1%) нь авто тээврийн хэрэгсэл, 4 (4.6%) нь бусад хулгайн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс авто тээврийн хэрэгслийн хулгай хамгийн их буюу 42.1 хувь буурсан байна.

Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилдаг болсон. 2026 оны 6 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3473 (94.5%) нь хөнгөн хэрэг, 202 (5.5%) нь хүнд хэрэг байна.


ХҮСНЭГТ 11.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2026 оны 6 дугаар сард

Төрөл		Бүгд	
		Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
		Тоо	Тоо
Нийт гэмт хэрэг		3 675	2 029
Хэргийн ангилал	Хөнгөн	3 473	1 917
	Хүнд	202	112
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	10	7
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	23	14
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	439	236
	Хүчиндэх	31	17
	Хулгайлах	522	285
	○ Иргэдийн өмчийн	400	220
	○ Авто тээврийн хэрэгслийн	11	8
	○ Халаасны	87	46
	○ Бусад	24	11
	Дээрэмдэх	72	36
	Залилах	1 835	935
	Танхайрах	2	2
	ХАБТХАЖЭ ²	96	49
	Бусад	645	448
			197


Нийт бүртгэгдсэн 3675 гэмт хэргээс 2029 (55.2%) нь цагдаагийн I хэлтэст, 1646 (44.8%) нь цагдаагийн II хэлтэст гарч, өнгөрсөн оны мөн үеэс I хэлтэст 460 (29.3%), II хэлтэст 203 (14.1%) хэргээр тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн

187 (69.0%) нь согтуугаар, 216 (2.2 дахин их) нь бүлэглэн, 750 (2.9 дахин их) нь эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг байна.

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цаг, гарагаар, жил бүрийн 6 дугаар сард

Энэ оны 6 дугаар сарын байдлаар даваа, мягмар, баасан гаригт хамгийн их буюу 1641 (55.3%) гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их үйлдэгдсэн нь мягмар гарагийн 06:00-14:00 цагийн хооронд байна. Дүүргийн хэмжээнд 2026 оны 6 дугаар сарын

байдлаар гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн газар болох гэр, орон сууцанд 1468 (39.9%) хэрэг, гудамж талбайд 1063 (28.9%) хэрэг, олон нийтийн газарт 593 (16.1%) хэрэг, бусад үйлдэгдсэн газар 551 (15.1%) тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн 6 дугаар сард

Гэмт хэргийн гаралтыг хороо тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20-р хороо 55 (30.2) хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол бусад хороодод 2.8 хувиас 1.1 дахин их хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Дүүргийн долоодугаар хорооны нутаг дэвсгэрт 471 (62.4%) гэмт хэргийн бүртгэгдсэн нь хамгийн их байсан бол хамгийн бага нь 21, 23, 27, 30, 34 дүгээр хороодод бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12.

НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2026 оны 6 дугаар сард

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	Тоо										
Бүгд	3 675	10	23	439	31	522	72	1 835	2	96	645
I хороо	302	-	-	10	1	19	4	77	-	3	188
II хороо	305	2	-	7	-	34	3	227	1	8	23
III хороо	177	-	-	13	-	11	1	115	-	4	33
IV хороо	95	1	-	13	1	16	2	25	-	5	32
V хороо	93	-	2	17	2	26	2	26	-	6	12
VI хороо	122	-	-	16	-	17	2	60	-	8	19
VII хороо	471	-	-	16	-	10	2	426	-	3	14
VIII хороо	82	1	1	24	1	13	3	27	-	2	10
IX хороо	77	-	-	18	2	21	3	23	-	2	8
X хороо	55	-	-	9	1	8	3	18	-	1	15
XI хороо	197	-	1	16	1	26	2	114	-	5	32
XII хороо	67	-	3	15	2	8	1	20	-	2	16
XIII хороо	136	-	2	22	-	21	5	68	-	4	14
XIV хороо	118	-	-	28	1	31	4	32	-	2	20
XV хороо	59	-	-	8	1	8	1	27	-	1	13
XVI хороо	171	1	2	20	-	25	3	101	1	2	16
XVII хороо	110	1	-	26	4	16	3	37	-	3	20
XVIII хороо	94	-	-	11	-	13	-	39	-	5	26
XIX хороо	75	1	1	16	-	18	2	27	-	2	8
XX хороо	127	1	2	18	2	18	3	58	-	7	18
XXI хороо	37	-	-	4	1	3	1	20	-	-	8
XXII хороо	57	-	2	17	5	9	5	12	-	2	5
XXIII хороо	31	1	-	6	1	5	2	7	-	6	3
XXIV хороо	94	-	2	13	-	24	1	41	-	-	13
XXV хороо	54	-	-	9	2	8	-	21	-	1	13
XXVI хороо	98	1	2	14	1	20	-	39	-	3	18
XXVII хороо	35	-	1	6	-	6	-	16	-	1	5
XXVIII хороо	38	-	-	3	-	10	2	20	-	-	3
XXIX хороо	119	-	1	14	1	25	5	56	-	3	14
XXX хороо	19	-	-	1	-	7	-	8	-	1	2

Гэмт хэрэг


Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	Тоо										
XXXI хороо	47	-	-	8	-	14	3	15	-	2	5
XXXII хороо	39	-	-	5	1	14	-	13	-	1	5
XXXIII хороо	38	-	-	6	-	9	4	13	-	1	5
XXXIV хороо	36	-	1	10	-	9	-	7	-	-	9

Бүртгэгдсэн зөрчил:

Дүүргийн нутаг дэвсгэрт энэ оны 6 дугаар сарын байдлаар 19182 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1494 (7.1%) хэргээр буурч, зөрчил гаргасан 19011 иргэн, хуулийн

этгээдийг 737.8 сая төгрөгөөр торгосон бол 270 хүнийг “Зөрчлийн тухай” хуулиар баривчилжээ. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 44.8 хувь нь I хэлтэст, 55.2 хувь нь II хэлтэс тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, хэлтсээр, жил бүрийн 6 дугаар сард



Нийт илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт, илрүүлэлтийн хувийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад I хэлтэс 114 (1.3%) хэргээр өссөн бол II хэлтэс 1608 (13.2%) хэргээр буурсан


байна. Нийт илрүүлсэн зөрчлийг нийслэлийн 9 дүүргийн хэлтсүүдтэй харьцуулахад Баянгол дүүргийн цагдаагийн II хэлтэс гуравдугаарт, I хэлтэс наймдугаарт эрэмбэлэгдэж байна.

Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл:

Дүүргийн хэмжээнд 2026 оны 6 дугаар сарын байдлаар 13205 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 7325 (55.5%) нь гэмт хэргийн

шинжтэй, 5880 (44.5%) нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл ирсэн байна.

ЗУРАГ 9.

БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, шалган шийдвэрлэсэн байдлаар, 2026 оны 6 дугаар сард


Гэмт хэргийн шинжтэй 7325 гомдол мэдээллийн 6830 (93.2%) хэргийг шийдвэрлэснээс 2635 (38.6%) нь хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн, 3959 (57.8%) нь хэрэг нээхээс татгалзсан, 236 (3.4%) нь харъяаллын дагуу шилжүүлэн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэсэн 6830 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 5 хоногт 1071 (15.7%) хэргийг, 6-19 хоногт 5735 (83.9%) хэргийг

тус тус шийдвэрлэн ажиллажээ. Нийт шалган шийдвэрлэгдсэн зөрчлийн шинжтэй 5880 гомдол мэдээллийн 5817 (99.0%) хэргийг шийдвэрлэснээс 2627 (45.1%) хэрэгт зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 3165 (54.4%) хэргийг нь зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 18 (0.3%) хэргийг нь харъяаллын дагуу шилжүүлсэн байна.

Зам тээврийн осол, зөрчил:

2026 оны 6 дугаар сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт ослын шинжтэй 10863 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 684 (5.9%) дуудлагаар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 10.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, дүүргээр, 2026 оны 6 дугаар сард

Улаанбаатар хотод нийтдээ 9833 зам тээврийн осол бүртгэгдсний 3208 (32.6%) нь Баянзүрх, 1930 (19.6%) нь Хан-Уул, 1318 (13.4%) нь Сонгинохайрхан, 1576 (16.0%) нь Баянгол, 1219 (12.4%) нь Сүхбаатар, 455 (4.6%) нь Чингэлтэй, 97 (1.0%) нь Налайх, 9 (0.1%) нь Багахангай, 21 (0.2%) нь Багануур дүүргүүдэд байна.

Бүртгэгдсэн ослыг дүүргийн хэмжээнд өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл 9.7 хувиар, эд материалын хохиролтой осол 9.4 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 13.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, төрлөөр, жил бүрийн эхний 6 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	<u>2026 I-VI</u> <u>2025 I-VI</u>
	Тоо			хувь
Нийт	1 965	1 746	1 576	-9.7
Эд материалын хохиролтой осол	1 750	1 579	1 430	-9.4
Хүн гэмтсэн осол	215	167	146	-12.6

Нийт зам тээврийн осол 1576 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 170 (9.7%) буурсан эерэг өөрчлөлттэй байна. Нийт бүртгэгдсэн зам тээврийн ослын 149 (9.4%) нь эд материалын хохиролтой осол, хүн гэмтсэн осол 21 (12.6%) тус тус буурсан байна. 2026 оны 6 дугаар сарын


байдлаар зам тээврийн ослын улмаас нийт 160 хүн бэртэж үүнээс хүн нас барсан 7 тохиолдол бүртгэгдсэн байна. Зам тээврийн ослын улмаас бэртсэн иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирсон иргэн 20 (11.1%) буурсан эерэг өөрчлөлттэй байна.

ХҮСНЭГТ 14.


ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС БЭРТСЭН ИРГЭД, төрлөөр, жил бүрийн эхний 6 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	<u>2026 I-VI</u> <u>2025 I-VI</u>
	Тоо			хувь
Нийт хохирсон иргэд	240	181	167	-11.6
Хүн гэмтсэн	238	180	160	-11.1
Хүн нас барсан	2	1	7	6.0**

ЗУРАГ 11.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, хэлбэрээр, тээврийн хэрэгслийн төрлөөр, дүнд эзлэх хувь, 2026 оны эхний 6 дугаар сарын байдлаар

Нийт гэмтсэн хүний 93 (58.5%) хувийг явган зорчигч, 23 (14.5%) хувийг зорчигч, 35 (22.0%) жолооч, 8 (5.0%) хувийг дугуйтай хүн эзэлж байна. Бүртгэгдсэн зам тээврийн ослын 1370 (86.9%) нь мөргөлдсөн, 108 (6.9%) нь явган хүн дайрсан, 78 (4.9%) нь үл хөдлөх зүйл мөргөсөн, 16 (1.3%) нь бусад байна. Зам тээврийн ослыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь 1324



(84.0%) нь суудлын, 109 (6.9%) нь ачааны, 48 (3.0%) нь автобус, 9 (0.6%) микроавтобус, 33 (2.1%) нь мотоцикл, 13 (0.8%) нь унадаг дугуй, 40 (2.6%) нь бусад эзэлж байна. Энэ оны 6 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 2342 (70.1%) хэргийг даатгалд шилжүүлж, 858 (25.7%) хэрэгт акт тавьж, 141 (4.2%) хэргийн өргөдлийг хүлээн авсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:
Дүүргийн Цагдаагийн I, II хэлтсийн сарын мэдээ



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

